

ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ МЭДЭЭ

Гадаад зах зээл

2023.10.27



ОНЦЛОХ МЭДЭЭ :

Хөрөнгийн зах зээлийн байдаг л нэг завсрын уналт уу аль эсвэл илүү том аюулын дохио юу?

Өнгөрсөн 7 хоногийн мэдээнээс онцлох зүйлс:

- Эдийн засаг тэсвэртэй хэвээр
- Инфляц буурсаар
- ХНС хатуу мөнгөний бодлогоо өндөрлөх ойртож байна
- Бондын өгөөж оргил цэгтээ хүрсэн
- Хувьцаануудын зах зээлийн үнэлгээ сайжирсан
- Компаниудын ашиг сэргэж байна
- Үйлдвэрлэл хамгийн хүнд үеэ давсан
- Газрын тосны ханшийн өсөлт тогтворжсон
- Хөрөнгө оруулагчдын дундах эргэлзээ багассан
- 11, 12 сарууд хөрөнгийн зах зээлд өсөлт авчирдаг улирлын онцлогтой

Онцлох мэдээ:

- ЗГҮЦ-ны өгөөж нэмж өсөх болон томоохон технологийн компаниудын санхүүгийн тайлан сайнгүй гарч байгаа нь хөрөнгийн зах зээлийг 7 сарын оргил цэгээсээ 10-аад хувиар унаж “correction” түвшинд хүргээд байна.
- Инфляц буурч буй энэ үед одоогийн уналт нь баавгайн зах зээлд хүрэхгүйг харуулсан 10 шалтгаан байна.
- Иймд, шинжээчид сайн хувьцаанаас хямд байгаа дээр нь авч багцаа нэмэгдүүлэхийг зөвлөж байна. Мөн хөрөнгө оруулагчдыг бодит байдалтай нийцсэн өгөөж, хэлбэлзлийн хүлээлттэй байхыг анхааруулж байна.

Хөрөнгийн зах зээлийг 7 сарын оргил цэгээсээ 10-аад хувиар унаж “correction” түвшинд хүрлээ. 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж 5%-д хүрэхээс гадна томоохон технологийн компаниудын тайлан дундаж байсан нь S&P 500 индексийг сүүлийн 5 сарын доод цэгт хүргэлээ. Хэдийгээр өнгөрсөн жилийн баавгайн зах зээлийн ёроолоос өсөхөд “Гайхалтай 7” компанийн хувьцаа голлон нөлөөлсөн бол энэ удаа тэдгээр нь захыг унахад хүргээд байна. Ингэснээр хөрөнгө оруулагчид энэ удаагийн зах зээлийн уналтыг түр зуурынх гэж үзэх үү эсвэл илүү том аюулаас болгоомжилсон нь дээр үү?

Зах зээлд тодорхой хэдэн сорилтууд байгаа ч U хэлбэртэй сэргэлт болох боломж байна

Шинжээчид ХНС-ийн өндөр бодлогын хүүгийн нөлөө эдийн засагт бүрэн тусгагдаагүй тул бага зэргийн хямрал тохиох боломжтой гэж үзэж байна. Ялангуяа сүүлд ажиглагдсан хэд хэдэн хүчин зүйлсээс үүдэн өнөөгийн зах зээлийн уналт баавгайн зах зээл болохгүйг илтгэж байна. Үүнийг харуулсан 10 шалтгааныг доорх байдлаар хүргэе.

1. Эдийн засаг тэсвэртэй хэвээр байна

- АНУ-ын засгийн газрын урьдчилсан таамгаар тус улсын эдийн засаг III улиралд 4.9%-иар өссөн нь шинжээчдийн таамаглаж байснаа өндөр байхаас гадна өмнөх улирлын үзүүлэлтээс 2 дахин өндөр байсан юм. Энэхүү хүчтэй өсөлт нь өрхийн худалдан авалттай холбоотой байв. Төсвийн зардал эдийн засгийн өсөлтөд тав дах удаагаа нөлөөлсөн бол байрны үнэ сүүлийн 2 жилд анх удаагаа өсөлт үзүүллээ.
- Шинжээчид энэхүү хүчтэй өсөлтийг удаан үргэлжлэхгүй гэж харж байна. Ялангуяа зээлийн хүү худалдан авалтыг бууруулснаар ирэх улирлуудад эдийн засаг унах хандлагатай байгааг онцолж байна.

ХНС-ийн бодлого чангарахын хэрээр худалдан авах чадамж өсөв
III улирлын ДНБ-ний өсөлтөд үзүүлсэн нөлөө



2. Инфляц буурсаар байна

Хэдийгээр эдийн засаг өсөж, ажилгүйдлийн түвшин бага хэмжээнд байгаа ч инфляц унах хандлагатай хэвээр байна. Суурь өрхийн худалдан авалтын үнийн индекс (PCE) 3.8%-иас буурч 3.7%-д хүрсэн. Энэ нь ХНС-ийн зорилтот 2%-иас их ч өнгөрсөн жилийн 5.6%-иас харьцангуй багассан үзүүлэлт юм.

3. ХНС хатуу мөнгөний бодлогоо өндөрлөх ойртож байна

Энэ 7 хоногийн мөнгөний бодлогын хурлаар ХНС бодлогын хүүг өсгөлгүй барих хүлээлттэй байна. Үүний шалтгаан нь ЗГҮЦ-ны өгөөж аль хэдий нь ээ хүчтэй өссөн байгаа тул бодлогын хүүг нэмэх шаардлагагүй харагдаж байна. Өнгөрсөн түүхээс харахад, ХНС хамгийн сүүлд бодлогын хүүг өсгөснөөс буулгахын хооронд хөрөнгийн зах зээл 5 удаа хүчтэй өсөж, 2 удаа л багахан (1987, 2001) өссөн байна. Харин бонд 7 удаагаас 6-аад нь дунджаас илүү өсөж байжээ.

Сүүлчийн өсөлт	Эхний бууралт	Бодлогын хүүгийн сүүлчийн өсөлтөөс бууралт хоорондын зай (сараар)	S&P 500-ийн өгөөж	Хөрөнгө оруулалтын зэрэглэлийн бондын өгөөж
1984-08	1984-10	1	11%	4%
1987-09	1987-10	1	-2%	-2%
1989-02	1989-06	3	11%	7%
1995-02	1995-07	5	19%	10%
2000-05	2001-01	8	-7%	11%
2006-06	2007-09	15	25%	10%
2018-12	2019-07	7	18%	7%


4. Бондын өгөөж оргил цэгтээ хүрсэн

10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж сүүлийн 16 жилийн дээд цэгт хүртэл өссөн нь хувьцаа болон бондын ханшид сөргөөр нөлөөлсөн билээ. Өгөөжийн түвшнийг яг хэзээнээс унаж эхлэхийг хэлж мэдэхгүй ч эдийн засгийн өсөлт саарч, ХНС бодлогын хүүг 2024 оноос буулгаж, инфляц 2% руу дөхөснөөр өгөөж унана.

5. Хувьцаануудын зах зээлийн үнэлгээ сайжирсан

• Хөрөнгийн зах зээлд тохиосон сүүлийн уналт S&P 500 индексийн үнэ ашгийн харьцааг 19-өөс 17.4 хүртэл буурахад хүргэжээ. Өнгөцхөн харахад, өнөөгийн бондын өгөөжийг хувьцааны үнэлгээтэй харьцуулахад хямдхан биш байгаа ч хөрөнгийн зах зээлийн ихэнх салбарт хямд хувьцаанууд байна. Жишээлбэл, S&P 500-ын ижил жингээр тооцоолсон индексийн үнэ ашгийн харьцаа 14-тэй, Russell 1000 хямд индекс 13-тай байгаа нь “Гайхамшигт 7”-ийн 30-аас хэд дахин бага буюу хөрөнгийн зах зээлийг том дүр зургаараа хямд байгааг илэрхийлж байгаа юм.

• Бондын өгөөж өндөр байгаа нь ханшийг түүхэн их хэмжээгээр унахад хүргэсэн тул сэргэх магадлал өндөр байна. 1%-ийн өгөөжийн уналт бондын ханшид 1%-ийн өсөлтөөс хамаагүй илүү өгөөжтэйг доорх зургаар дүрсэллээ.



6. Компаниудын ашиг сэргэж байна

Компаниудын ашиг 3 улирал дараалан унасан боловч энэ III улиралд өсөж, цаашлаад 2024 онд өсөх хандлагатай байна. Эрэлт сайн байгаа нь борлуулалтыг өсгөж, инфляц буурч байгаа нь өртөг буурахад хүргэсэн нь ашигт ажиллагаанд сайнаар нөлөөлж байна. Хэдийгээр шинжээчдийн ирэх жилийн ашгийн өсөлт 12%-тай байгаа нь хэд өндөр байж болзошгүй ч хөрөнгийн зах зээлийн өсөлтөд эергээр нөлөөлөх юм.

7. Үйлдвэрлэл хамгийн хүнд үеэ давсан

Үйлдвэрлэл өнгөрсөн жил хамгийн ихээр буурсан билээ. Гэвч өнгөрсөн 7 хоногийн S&P Global-ийн PMI индекс өсөлт үзүүлснээр ёроол тогтож байгаагийн илрэл байж болох юм. Үйлчилгээний салбартай харьцуулахад үйлдвэрлэлийн салбар эдийн засгийн багахан хэсгийг бүрдүүлдэг боловч сэргэлтийн дохио байдаг зүй тогтолтой.

8. Газрын тосны ханшийн өсөлт тогтворжсон


Геополитикийн хурцадмал байдал газрын тосны ханшийг 90 доллароос дээш гарахад хүргэсэн боловч нэмж өсөөгүй нь эрчим хүчний үнийн өсөлтийг харьцангуй тогтвортой байлгаж 10 сарын инфляцыг өсөхгүй байхад нөлөөлж болох юм.

9. Хөрөнгө оруулагчдын дундах эргэлзээ багассан

Оны эхээр хиймэл оюун ухаантай холбоотойгоор хөрөнгийн зах зээл ихээхэн өөдрөг байсан ч сүүлийн үед буурсан. Хөрөнгө оруулагчдын итгэл хэт багасан нь ихэвчлэн ёроол бүрдэж байгаагийн дохио байдаг.

10. 11, 12 сарууд хөрөнгийн зах зээлд өсөлт авчирдаг улирлын онцлогтой

Хөрөнгийн зах зээлийг суурь үзүүлэлтүүд хөдөлгөдөг ч түүхээс харахад улирлын шинж чанартай зүй тогтлууд байдаг. 1945 оноос хойш 11, 12 саруудад S&P 500 индекс дунджаас дээш өгөөжтэй байсан ба хамгийн өндөр эерэг өгөөжтэй байх магадлалтай сарууд байж.




Завсрын хөдөлгөөнүүдийн түүхээс хуваалцахад:

Энэ сарынх шиг уналтын завсрын хөдөлгөөн нь хөрөнгө оруулагчдад хүнд байдаг ч олон тохиолддог үзэгдэл юм. 1971 оноос хойш 18 удаа завсрын хөдөлгөөн баавгайн зах зээл болж байгаагүй ба дундаж уналт 14.5%-тай, 4.3 сар үргэлжилсэн байна. Эдгээр баавгайн зах зээлтэй ойрхон болсон завсрын хөдөлгөөнөөс хойш хөрөнгийн зах зээл хагас жилийн дараа 17%, бүтэн жилийн дараа 23%-ийн өсөлт үзүүлж байсан.

Өнгөрсөн удаагийн завсрын хөдөлгөөнүүд мөнгөний бодлого, эдийн засгийн уналт, геополитикийн мөргөлдөөн, хөөсрөл зэрэг бишгүй зүйлсээс шалтгаалж байсан боловч S&P 500 индекс алдагдлаа ёроол тогтсоноос хойш 4 сарын дотор нөхөж байсан юм.

S&P 500 индексийн өгөөж уналтын үеэр болон дараа



Замд таарсан тотгор болохоос 2022 оны үргэлжлэл биш

- Ирээдүйд эдийн засаг саарч, хөдөлмөрийн зах зээл унаж, геополитикийн тодорхой бус байдал сайжрахаас нааш хэлбэлзэл буурахгүй үргэлжлэх болов уу. ХНС инфляцыг зорилтод түвшин хүртэл бодлогын хүүг өндөр түвшинд барьснаар зах зээлийн сэргэлт ойрын үед тохиохгүй байх магадлалтай.
- Сүүлийн үед инфляц өсөөгүй нь бид хамгийн хүнд үеэсээ мултарсан байж магадгүйг илтгэж байна. S&P 500 арилжааны нийт 455 өдрийг шинэ оргил цэг тогтоолгүй өнгөрсөн нь Санхүүгийн Хямралаас хойших рекорд юм. Цөөн хэдэн хувьцааг үл тоовол S&P 500 индексийн бусад хувьцаанууд түүхэн доод үнэлгээндээ хүрсэн.
- Хөрөнгө оруулагчид энэ үед сайн чанарын хувьцаануудаас хямд үнэлгээ нь дээр авах боломж бүрдэж байгаа ба бонд, хувьцаанаас төрөлжүүлэлт хийн хөрөнгө оруулалтын багцаа бүрдүүлэхийг зөвлөж байна.

САНАМЖ

Энэхүү мэдээлэл нь Ард Секюритиз ҮЦК-иас зөвхөн мэдээллийн зорилгоор бэлтгэгдсэн болно. Илэрхийлсэн үзэл бодол нь зөвхөн шинжээчийн байр суурийг илэрхийлэх бөгөөд зах зээл болон бусад хүчин зүйлсийн нөлөөллөөр өөрчлөгдөх боломжтой юм. Бүх мэдээ, мэдээллүүд нь үүнд Ард Секюритиз ҮЦК-ийн эх сурвалж болгосон буюу гаргасан мэдээлэл үнэн бодит гэж үзсэн эх сурвалжаас авсан боловч нарийвчлал нь баталгаажуулаагүй болно. Өнгөрсөн үзүүлэлт нь ирээдүйн үр дүнгийн баталгаа болохгүй. Тиймээс та өөрт нийцсэн хөрөнгө оруулалт эсвэл арилжаа хийхдээ бие даан буюу өөрийн зөвлөхтэйгөө зөвшилцөж шийдвэр гаргах хэрэгтэй гэдгийг анхаарна уу!